

УДК 930.85+82.12

ӨВӨР МОНГОЛЫН ЯРУУ НАЙРАГЧ Д. ЦЭРЭНВАНЖИЛЫН НАЙРАГЛАЛ, НАЙРУУЛЛЫН ҮНДЭСНИЙ СОЁЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Цоморлиг С.

Монгол Улсын Улаанбаатарын их сургуулийн докторант
Улаанбаатар, Монгол Улс
E-mail: 2676423124@qq.com

Товч хураангуй

Яруу найраг бол уран зохиолын төрөл зүйл. Жинхэнэ яруу найраг бол шидэт юм. гоо үзэсгэлэн, сэтгэл хөдлөл, мэдрэмж, хайр, амьдрал үгээр дамжуулан илэрхийлж чаддаг. Яруу найргийг соёлын илрэл болгон тодруулах зорилгоор монголчуудын бүтээсэн яруу найргийн эрдэнэсээс гайхамшигуудыг олж нээх хэрэгтэй. 1980 оноос Өвөр Монголын яруу найрагт ихээхэн хувиралт гарсан билээ. Үүнээс өмнө үед уран зохиолыг нам төрийн үзэл суртлын хатуу шаардлагаас болоод амьдралын уянга, байгалийн зураглал хааяа нэг харагдсаныг эс тооцвол чөлөөт уянга, түүхийн сэдэвт яруу найраг бараг байхгүйтэй адил байжээ. 1970 оны сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь гадаадтай чөлөөтэй харилцан, улс орнуудтай соёлын солилцоог ахиулах хандаштай болсноос Хятадын шинэ үеийн шүлэгчдийн дунд модернизмын чиглэлийн яруу найргийн өрнөлт гарч, уран зохиолд шинэ өнгө аяс бий болсон байна. Өвөр Монголын яруу найраг ч маш түргэнээр шинэ амьсгал авч эхлэн угийн уламжлалт үндэсний яруу найргийн хэв маяг дээр модернист яруу найргийн шинэ хэв маягийг идээшүүлэн хэрэглэж үндэстний түүхийн талаар эргэцүүлэл тунгаалт хийж, үндэстний хувь заяаны талаарх бодлогошролын уран сайхны ч цоо шинэ арга барилаар илэрхийлж эхэлсэн байна. Яг энэхүү түүхэн цаг үед Д. Цэрэнванжил нь наяд оны эхэн үеэс яруу найргийн гараагаа авч, шинэ цаг үеийн яруу найргийн хошууч болсон байна. Д.Цэрэнванжил Өвөр монголын утга зохиолын дээд шагнал “Солонго” шагналыг «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» найраглалаараа 1987 онд хорин зургаан насандаа, 2008 онд дөчин долоон насандаа «Нууц товчооноос тасарсан адуу» найраглалаараа хүртсэн.

Түлхүүр үг

Өвөр Монгол, яруу найраг, Д. Цэрэнванжил, соёл, найраглал.

UDC 930.85+82.12

NATIONAL CULTURAL SIGNIFICANCE OF POETRY OF INNER MONGOLIA POET D. TSERENVANZHIL

Tsomorlig S.

Doctoral student at Ulaanbaatar University, Ulaanbaatar, Mongolia

E-mail: 2676423124@qq.com

Annotation

Poetry is a literary genre. True poetry is magic. beauty, emotions, feelings, love and life can be expressed through words. In order to highlight poetry as a cultural manifestation, we need to discover the wonders of the poetic treasures created by the Mongols. Since 1980, there has been a significant transformation in poetry in Inner Mongolia. In earlier times, literature was almost like free poetry and historical fiction, except for the occasional appearance of natural imagery of life, due to the strict demands of partisan political ideology. Since the late 1970s, the people's Republic of China has had to deal with foreign freedom and advance cultural exchange with countries, and a new generation of Chinese poets has developed a new tone in literature. The poetry of Inner Mongolia has taken on a new breath and has developed a new style of modernist poetry in the traditional style of National Poetry, reflecting on the history of the nation and expressing a completely new way of thinking about the fate of the nation. At this very historical time, D. Tserenvanzhil took a career in poetry from the beginning of the eighties and became a major in poetry for the New Times. D. Tserenvanzhil won the Supreme literary prize of Inner Mongolia, the Rainbow prize, for his composition "the world on a high rise" in 1987 at the age of twenty-six, and in 2008 at the age of forty-seven, for his composition "the horse who broke the secret".

Keywords

Inner Mongolia, poetry, D. Tserenvanzhil, culture, poem.

О Р Ш И Л

Д. Цэрэнванжилын найраглалын үндэсний шинж

“Трекийн хийе, бүтээе гэсэн үгнээс гаралтай, том хэмжээний шүлэглэсэн зохиол ба түүний өгүүлэмж нь хүүрнэлийн ба уянгын шинжийг хадгалсан байж болдог. Эртний ба дундад зууны үед гарсан том хэмжээний зохиолуудыг голдуу нэрлэдэг бөгөөд их туульсыг ч ингэж нэрлэх явдал бий. Анх үүсэж буй болж байсан найраглалын үндсэн шинж нь зохиогчгүй домгийн болон үлгэр туульсын сэтгэлгээнд дулдуйдсан, их туульсын зохиолоос үүсэн буй болж тухайн улс үндэстний түүхэн онцгой ач холбогдол бүхий үйлсийг үзүүлсэн байдаг” (Байгалсайхан, 1995: 56) гэснийг баримталбал тэрбээр зургаан найраглал бичиж нийтлүүлжээ.

Түүний дурсан ярьснаар “Миний хувьд монголчуудын ариун цайлган сэтгэл, адуу малтайгаа дөрвөн зүг найман зовхистоо бэлчиж, уужуу уяруун амьдарч орогносон байгалийн араншингаар хүн нийгмээ тэтгэх бол юунаас ч эрхэм. Дэлхийд өөр биднийг хайрлаж тэтгэдэг үндэстэн байхгүй. Бид монголоороо байх л учиртай, биднийг монголоор нь байлгаж чадах бүх эд эрдэнэсийг өвөг дээдэс минь аль эрт нэгэнт бүтээжээ. Яруу сайхнаар яруу найргаа бодож сэтгэдэг сэтгэлгээгээ бид гадаадаас авах ёсгүй. Ингэж би «Дөрөөн дээр өндийсөн дэлхий», «Нууц товчооноос тасарсан адуу» гэдэг хоёр найраглалаа бичсэн” гэсэнчлэн түүний энэ бүтээлийг уншихад Монгол ахуй зүүдлэгдэх шиг болдог.

Түүний 1986 онд «Шилийнгол» сэтгүүлд хэвлүүлсэн «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» найраглал нь оршил уянга, чулуу, ой мод, мөрөн гол, өндөрлөг, төгсгөл уянга гэх зургаан хэсэг мөчлөг уянгаар бүтжээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нэг. Оршил уянга

Эх газар минь ээ

Манаж явсан гал

Мянган лан алт юм аа гэж

Нар зүтгүүлэх аяныхаа

Амьсгалын тоолонгоор захисан

Сургаалыг чинь чагнаж

Талын мөнгөн шүүдэр шиг

Монгол гэрийн хаяанд

Газрын бүлээн амьсгаатай

Хайрын бүүвэй нэмж төрлөө би.

гэж эхэлдэг. Монгол хүн голомтын галаа бөхөөхгүй манасаар ирсэн, эртний дээдсийн захиа сургаалыг умартаагүй ирсэн ард түмнийхээ үг болгож түүхэн цаг үеийн эхлэлийг яруу найрагч бичиглэсэн юм. Монгол гэрийг “талын мөнгөн шүүдэр шиг” гэж зүйрлэсэн нь маш шинэ соргог дүрслэл байж:

Нутаг алсын хөөрхий бараа

Нүүдэл далласан уйтгартай төрлөө би

Эх газар минь ээ

*Эргэж хармаар санагдах
Дандаа шаргал бүрийтэй
Эх газар минь ээ*

гэсэн нь нүүдэл биднээс тасран холдож байгаа талаарх эмзэглэл байж, нүүдлийн ахуйд сэтгэл хоргодсон дандаа шаргал бүрийтэй монгол газартаа хайр хоргодсоноо чөлөөт задгай мөр бадгийн хэлбэрээр илэрхийлсэн.

Хоёр. Чулуу

*Энэ бөмбөрцгийн түүх
Чулуу болно
гээж эхэлж
Чулууны дээгүүр
Он тоолууд тэмцэлдэж
Уранхай тэмдэглэл болов.*

Дээр өгүүлсэнчлэн “Чулуу” гэсэн үг тус уран бүтээлчийн зохиол бүтээлд өдий төдий бий. Энд түүхийг чулуун дээрээс уншиж амьтай байсан бүхний ая дууг амьгүй үлдсэн чулуун дээрээс мэдрэн чагнаснаар бичсэн. Чулуу нь аливаа үнэн ёсны мөнхийн бэлгэдэл дүр болон илэрчээ.

Тус мөчлөг уянгын төгсгөлийн хэсэгт:

*Малынхаа хөл дагаж
Монгол газрын чулуу
Ачаа дагаж нүүдэллэж явна.
Газрын нэг чулууг
Буцааж шидэх зүрх
Надад байхгүй.*

гэж бичсэн нь нүүдэлчин удамт ард түмний амьдралын онцгой зураглал юм. Ачаа дагаж нүүдэллэсэн чулууг буцааж шидэх тийм хатуу зүрх, зөвхөн монгол хүнд байхгүйг сургамжилсан. Чулууг нүүдлийн бэлгэдэл болгон өгүүлсэн.

Гурав. Ой мод

*Чамайг хараад би
Исгэрье гэж саналаа
Итгэж ядмаар зураг шиг байгаль
Их өндөрлөгийн уул тайгаа
Ид насныхаа хийморио хэмээн
Исгэрье гэж саналаа би.*

гэсэн нь энэ эхлэлт нь монгол яруу найрагт урьд өмнө огт харагдаж байгаагүй сэтгэлгээний шууд тэсрэлтээр маш тулгам эхэлжээ. “Исгэрье гэж саналаа” гэсэн үгээр уянгальнхаа айзам болгож, монгол хүний ой ухаан нь өвс ургамал, ой модноос сэрэл авдаг, шим авдаг амьдрахын халуун урам, амь насны эрчим хүч авдагийг урлагийн аргаар үзүүлж байна. Ой мод гэсэн уянгад байгалийн эвдэгдлийн талаарх харамсал харууслаа илтгэж байгаль нутаг усаа бодох хүнд цаг үе хүрч ирсэн гэдгийг тодорхойлжээ.

Дөрөв. Мөрөн гол

*Өндөрлөгийн сэрүүн тэнгэртэйгээ
Зусаалд минь зүтгэж ирэх
Мөрөн голоо
Хунгийн цагаан цуваа юмдаа гэх ...*

... Харийн зүүд сарниулсан

Халх голын үеэр

Хад мөргөж хангинасан

Миний агуу ялагдах

Хатуу сорвитой үлдсэн

Миний ичгүүрт ялалт

Энд яригдаж буй гол мөрөн нь зөвхөн бодит гол мөрөн биш, үүх түүхийн урсгал, монгол хүний амь насны хөдөлгөөн байж таарна. Түүхэн зарим цаг үед бидний ялалт хар толбо байсан юм гэж шүүмжилсэн.

Чамайгаа гэж

Газар дээр ургасан

Өнчин элэг би юмаа

гэж энэ хэсэгт байдаг өнчин элэг өндөлзөнө гэж монголчуудын ярианд байдаг түүхээ гэж, монголоо гэж газар тэнгэр хоёрын заяасан монгол хүний төөрөг тавилан, монгол хүний сэтгэлийг ярьж байна.

Тав. Өндөрлөг

Өндөрлөг минь

Эртний хэн нэгэн хүний

Нутагтаа дуулсан

Холын чингэн дуу юудаа чи

Өндөрлөг бол тэр чигээрээ дуу байдаг юм. Монгол хүний дуу уянга бүхэн монголын өндөрлөгийнхөө зураг дүрс нь байдаг юм.

Онон Сэлэнгийн долгио

Өрнө дорнын зэрэглэгээ

Үзэмчин сөнидийн шилнүүд гэж

Нарны доогуур дуниартан бөмбөгнөж

Намрын зүс шүү

Сэмсэрхэн цэнхэр барааг чинь би

Сэрүү татсан нүүдэл дунд таньсан шүү би

Яруу найрагчийн зүрх сэтгэлд бүтэн мэдрэгддэг өндөрлөг ийм байх. Нүүдлийн түүх бол өндөрлөгийн өнгө зүс нь юм байна.

Уйлах уу даа,

Дуулах уу даа,

Нүүдэл чагнаж өндийсөн

Монгол миний хүйс дарсан

Уулын нэгэн чулуу юмдаа чи

Өнөөгийн монгол хүний сэтгэл бол уйлмаар ч, дуулмаар ч сэтгэл юм. Түүхээ бодохоор дуулмаар, төөргөө санахаар уйлмаар эхийн сэтгэлд нохой тэжээж дууссан шиг гаслам, гэвч өндөрлөг бүхлээрээ монголын хүй дарсан чулуу гэдэг ихэсгэх сэрэл нь шүлэгчийн нарийн мэдрэмжийн үзүүлбэр мөн. Өндөрлөг байна гэдэг хүй дарсан чулуу нь байна гэсэн үг, энэ нь яруу сайхан бэлгэдэлийн санаа.

Зургаа: Төгсгөл уянга

Хол газраас олон морьтон

Давхиж айсуу харагдана

Хол газрын тэнгэрийг

Өргөж чирч явна

Ирээдүй сайн сайхныг хүсэн мөрөөдсөн монгол хүний мөрөөдөл. Яруу найргийн зөн сэрэл ч энэ билээ. Найраглалынхаа төгсгөлд монгол хүний цог хийморь, сэргэл мандалтыг хурайлсан далласан байна. Ирээдүйн монгол, өндөрлөгтөө хөх тэнгэрээ өргөж хүрч ирж байна. Түүх ахуйг солбицуулан сэтгэсэн «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» хэмээх найраглал нь Д.Цэрэнванжилын монгол түүх ахуйн эргэцүүлэл, монгол хүний хувь заяаны талаарх санаашрал, монгол байгаль ахуйн зураглал. Зохиогчийн сэтгэлгээний өнгө аялгуугаар бүтээгдсэн байж, нэгэн цаг үеийн монгол хүний түүхэн ахуй, түүхэн сэтгэлгээ, түүхэн эрэлхийлэл юм.

Тус найраглал нь бүхэлдээ монгол ахуйд төрсөн, энэ ахуйгаа хүндэлдэг, энэхэн ахуйгаа хойч үедээ уламжилж үлдээх гэсэн уран бүтээлчийн зөн гэж хэлж болно.

Түүний 2018 онд «Балгарын долгио» найраглалын ботьд хэвлүүлсэн «Нууц товчооноос тасарсан адуу» найраглал нь:

Амьтанд үл гардах нэгэн сайн морь надад буулгаж өгөөрэй, эцэг минь!

— “Гэсрийн тууж” — аас

Аавын хэлсэн нэг үг яг мартагдахгүй, сүүлд нь мэнгэ юмуу, нэг хүнд юм зүрхэн дээр дарж, би шөнө шөнө зүүдэндээ ярьдаг боллоо хэмээн гэсрийн туужаас ишлэн эхэлдэг.

...Ергөсөн түмэн адууны салхи шиг

Ергөж зогссон

Түмэн адууны амьсгаа шиг

Ергөөдүй түмэн адууны эргэцээ шиг

Сэтгэлд дэвэлхийлэн эргэлдсэн

Сударт дэвэлхийлэн үлдсэн

Дорно дахны уулс

Монголын уулс аа...

гэж шүлэглэж өрнөдөг. Энэ оршил хэсэгт ерөнхийдөө монгол нутаг, баатар эр, адууны дүрслэл бий.

...Зэрлэг цагийн инээд ба

Хүний өшилтэй цуг залгисан

Эртний агаар

Нулимс минь

Буха хатаги бухату салжи, намайг

Хар нутаг дээрээ

Хаяж явахад

Хань болж үлдсэн

Орог шонхол морь минь ээ!..

хэмээн морь монголчуудын хань нөхөр гэдгийг магтан дуулсан

...Сэлмээ сугалав !

Үндэс уруугаа дүрэлзэн шингэх

Ган халуун яс ба

Цусны урсгал

Өнгөрөх шөнө хайлсан туйлын баатар

Агуу их морьтой төрх

Дөрөө нь хангинаж сонсдоно

Арван долоон түмэн хүн

*Амиа дэвсэж ирсэн
Аймишигт энэ аян
Ази европ-ийн хуурайн
Амьд шарх болж тогтов
Аянга болж зангирав
Алаг хоёр нүдэнд минь
Цус үсэрч тогтов...*

Өнөө үеийн сэхээтний оюунч ухаарал, учиртай сэнхрүүлэл, уянгын жавхаатай өөрийн үндэстнийхээ өнгөрсөн удамшлын хүчин, байх учиртай цусны хүчин, байхгүй болсон ч эрэх учиртай мөнхийн хүчний тухай олон бодол ургах учиртай. “Нууц товчооноос тасарсан адуу” түүхийн их хөндийгөөс эзнээ эрэн үүрсэлдээ ч болов уу?

“Ергөсөн түмэн адууны салхи” бол цахилж өнгөрсөн түүхэн үнэний хөдөлгөөнт бэлгэдэл, “ергөж зогссон түмэн адууны амьсгаа” бол аялж ирсэн түүхээ эргэцүүлж, эсхүл зовниж байгаа санаа алдал буюу бодол тайвшралт “ергөөдэй түмэн адууны эргэцээ” бол дарж болшгүй тэмүүлэл, удмын авьяас эсхүл хоригдож, хураагдах тэсгэл алдран байгаа арга бусын тэсвэр ч юм уу?

Морь, монголчуудын соёлын хүлэг бэлгэдэл дүр байх учиртай. “Нууц товчоо” ба “тасарсан адуу” хоёрын дотоод холбоо ч үүнээс ирсэн байгаа юм. “Тасарсан адуу”-ны эрэлд давхиа эрэлчний сонорт адууны чимээ хааяа тод, хааяа бүрэнхэн сонстоно, хааяа урамтай, хааяа гунигтай сонстоно .

*...Тэнгэрээс бүдүүн харанхуй
Нүдэн дээр унав
Адуун дээр унав гэж зүүдэлж сэрлээ би...*

“Би” түүхийн адуудыг хааяа холоос дурандан, хааяа захад нь давхиж, хааяа дөрөөн дээрээ омголон исгэрч, хааяа эрлийн холд уйтгартай дэншинэ. Энэ бол шүлэгч “морь” буюу “адугу” хэмээх бэлгэдэлтэй санаа дүрийг цогцлон босгохдоо уянгын айзмаа амьдлаг хөдлөнгүй, уран болгохын тулд зорилготойгоор сонгосон түүхийн ба өнөөдрийн эсхүл хувь цогцын хараа байж таарна. “Эрэлчин” хүн болсон хойно дурангийн харааг хол тавьж уужим хараалах нь зүйтэй.

Утга гүн, санаа хол, уянга цэмцгэр найраг бүтээхэд амь насны дотоод ухаан, хэлний шидээр дүржин амилж, сэтгэлгээний аясаар уянгажин илэрнэ.

*...Ингэр жингир чинь биш үү
Ярам жарам нүд чинь биш үү
Инээн дуулан нутаг чинь биш үү...*

хэмээн “ уянгын эхэнд” туульсжуун догдлуун уянгалж гарч ирснээ

*...Нулимс шиг ганзага нь асгарах шиг
Нэгэн морьтон айсуу цоо яваа болов уу...*

гэж уянгын жолоо татасхийн хатирч, уншигчдын сэтгэлгээг өөр нэгэн аяс зүг хөтөлнө.

*...Монгол минь, чи
Нэрээсээ эхлээд тайлбаргүй
Дэлхийн чулуунд шингэсэн
Нууц
Тэргын хилэнтэй зэрэгцэж
Нярхийж бараад
Дахин атгарсан
Дайны халуун цанх...*

*Газрын өлөн түймэр
Дайны нууц гүлгэн
Монгол минь
Надад, чамаас илүү
Утга агуулга байхгүй...*

гэж омголон агаад цаанаа хүнд дусалттай уянгалахын хэлбэршлээр найраглалын уянга санааны гүн зүгрүү тэмүүлнэ. Ийнхүү уянгын аяс, сэтгэлийн хөгийг чөлөөтэй солбицуулан жинтэй зохицуулахад “би” дүрийн уянгын хараа зогсцын амьдлаг хувирлын чухал нэгэн урлал болсон байна. Тэгэхлээр “би” бол найраглалын орон зай дахь уянгын санаа дүрийг холбон цогцлогч буюу шижим мөн бөгөөд түүхийн хариуцлагат овор ба ахуйг шүүмжлэн сэнхрүүлэх ухамсраараа найраглалд уусан тодорно.

Нүүдлийн тоостой Монголын өндөрлөг дээр хувь заяаны түүх цадигаа бичиглэсэн нүүдэлчин угсаатны соёл түүхийн анарыг үзүүлэхэд тэдний амьдрал ахуй, ааль араншин, саарал мэдрэмж, сэтгэх хэлбэр дунд нь зохицсон хэлний үнэт материалыг шаргаан авах бол уран бүтээлийн олноо таалагдах улбаагаа эзлэхийн дээд шаардлага. Тэрбээр амьдрал ахуйн жирийн санаа бүхий хэллэгийг утгын дээд түүхийн үнэ өртгийг шингээсэн хувийн жинтэй содон хэллэг болж мэдрэгдэнэ.

*...Тэнгэрийн хилэнтэй зэрэгцэж
Нярхийж бараад
Дахин атгарсан
Дайны халуун цанх...*

гэдэг санаа дүр дахь “хилэн” гэдэг үг дангаараа бол “догшин ширүүн, уур хилэн” гэх л утгатай, “цанх” гэдэг хүн малд тохиодог махбодын гэнэтийн шаналал юм. Гэтэл монголчуудын омголон догшин явсан ба багтарч бухимдаж явсан түүхэн үнэнтэй холбон утгажуулахад л амьдралаас давсан соёлын санаа дүр болж илэрнэ. Түүхийн даваанд бусдын эрхшээлд зовж зүдэрч явсаныг

*...Турсага шиг гөвж
Туурга шиг сэглэж
Байн байн гал уруу
Буцан буцан ус уруу
Шатаж үзнэ, сэгсэрч үзнэ...*

Амьдралын хэллэгээр дүрслэг мөртөө гүн санаатайгаар уянгалсан нь найрагчийн монгол амьдралын гүн нөөцтэй бөгөөд түүнээ боловсруулан шаргааж чадахуйц хэлний боловсролтой гэдгийг харуулж байна.

Тус хоёр найраглал нь ерөнхийдөө монгол ахуйн тухай болж өнгөрсөн хийгээд болж буй үйлийн өрнөлийг харуулсан байна.

Д. Цэрэнванжилын найруулал дахь нүүдэлчний соёлын ач холбогдол

“Агуулгын хэмжээ багтаамжаараа өгүүллэгтэй адил төстэй боловч буух эзэнтэй буцах мөртэй бодтой хүний үнэхээр болсон хэрэг явдлыг хүүрнэн өгүүлэх туульсын нэг зүйл зохиолыг найруулал гэнэ” (Гаадамба, 1989: 203). Д. Цэрэнванжилын уран бүтээлийн нэлээдгүй хэсгийг уран зохиолын найруулал эзэлдэг. Түүний бичсэн хоёр найруулал нь дунд сургуулийн сурах бичигт 2004 оноос өнөөг хүртэл монгол ахуй байдал, зан заншил, хүний эгэл амьдралыг мянга мянган Өвөр Монгол багачууд ойлгуулсаар байна.

“Мөнхийн зоог /ярилцаа/” найруулал*Мөнхийн зоог**Хүний сайхан сэтгэлийг байгаль төрүүлдэг ч болов уу?*

Нар зэрэглээнтэй Буурал ханы энгэр бэлээр тийм нэг өвгөн хүний уужим хатангир өвдгийг түшиж, “Сайхан байна шүү” гэдэг яриад бардаггүй зоогийг нь сонсож явснаа одоо бодвол их сайхан байжээ. Би тэр үед хүүхэд байв.

— *Хөө хүү минь чи чинь хонь сайхан хариулах юм байна шүү? Сайн малчин болох нь юм байна гэгчихсэн, бүдүүн гэдэстэй хөгшин цавьдартайгаа донишуулчихсан миний захад ирж, жилийн дөрвөн улиралд хонийг яаж яаж хариулахаас эхлээд, Буурал ханы тухай, заримдаа бүр ч “Саяны жил аав нь...” гээд л арвин сайхан учиртай юм ярьдаг байлаа. Бодвол өвгөн ганцаараа хонины захад суугаад уйддагтаа л тэр болоо байлгүй?*

— *Ай даа, хүү минь ээ, хүн өтлөвөл их л уйсдаг юм байна шүү. Нар байгалиа харвал, цэл залуу л байх юм билээ. Хүн ингээж залуугийн хийморьд сэргээж явдагтаа өвгөрөхөө мэддэггүй байна шүү гэж өвгөн үглэдэг байлаа.*

Нэг удаа өвгөн Буурал ханы энгэрийн нэг их настай болсон өвгөн хүний үлгэрийг ярьж сууна билээ. Тэр өвгөн хэзээд нартай зоог дэлгэж суудаг гэнэ. Заримдаа их л зоог таардаг нь бололтой. Хоёулаа бүр ч тэнийчихсэн, Буурал ханы энгэрт сайхан бараа нь дүнхийж, хүн байгалийн өег өнгөршүүн болж харагддаг гэнэ билээ. Чингээд өвгөн нь нарнаас гуйдаг юм байна: “Нар гуай, та хэчнээн удаа өтлөөд Буурал ханы ард унасан ч маргааш нь болоход залуу болчихоод Буурал ханы энгэрт ирдэг мөнхийн юмаа надад өгнө үү? Манай дэлхийн хүн харыг би тантай адил залуу байлгая гэж санах боллоо. Залуу халуун нас гэж яасан сайхан бэ! Түүний санаж хүсдэг нь, хийж бүтээдэг нь яасан ч сайхан байлаа” гэдэг гэнэ.

“Болохгүй шүү, өвгөн гуай хөө! Миний эзэн зөвшөөрөхгүй. Хэрвээ та өөртөө хэрэглэнэ гэвэл би танд авчирч өгье” гэж Нар хариу өгдөг байжээ.

“Үгүй, үгүй би чиний түүгээр чинь одоо юу хийнэ вэ? Гэвч та надаас гэрлээ харамлаагүйд би их сайхан насаллаа шүү, Нар минь” гэж өвгөн сэтгэл дүүрэн хэлдэг гэнэ шүү...

— *Үнэндээ ч тийм байна шүү. Залуухан байгалийнхаа элгэнд нартай зоогдож өвгөрнө гэдэг мөн сайхан шүү, хүү минь гээд өвгөн гуай хөмсөг сормуусгүй улаан зовхио өргөж намайг харж инээх нь яг л Нараа олж үзсэн шиг хөгжилтэй байлаа.*

— *Аав аа. Чингээд тэр өвгөн яав? гэж би асуусан байдаг.*

— *Аа? Тэр өвгөн үү? Сүүлээр нь өвгөн, Нарны эзнийг эрэхээр явлаа гэж хэлэлцдэг, их л хол байдаг гэнэ шүү. Ээ дээ, сайхан шүү, хүү минь, нарны мөнх гэрлийн сайхан золыг танай хүүхэд залуучууд л эзлэх буянтай шүү, аав нь одоо юу байх вэ, энэ хэдэн малынхаа хойноос донишуулж байгаад л явчихна. Удахгүй шүү, юу л удахав дээ? гэж өвгөн намуухан ярьж суудаг байсан.*

Өвгөн хоньчин, Нар болон өвгөний үлгэрийг их л урт ярьсан юм.

— *За, хүү минь, маргааш аав нь нарны мөнх гэрлийг чухам хэн авчирч чадахыг ярина шүү гэж хэлсний маргааш нь тэр сайхан үлгэрийг сонсож чадалгүй сургуулийн босгыг алхсан байж билээ би. Маргаашийнх нь тэр үлгэрийг нь сонсьё гэж би их дурлаж хүссэн болохоороо өвгөнийг их л санадаг байлаа. Ер нь чингээд сайхан нартай хөдөөгийн билчээрт тийм нэг өвгөн хүмүүний нам дөлгөөхөн яриаг сонсож суух нь яг л хүн байгалийн эрт язгуурын их урсгалын чимээг чагнаж байх шиг учиртай гоёхон санагддаг байж билээ.*

Сүүлээр нь би өвгөнтэй дахиж уулзсангүй билээ. Гэлээ ч тийм нэг энгэр дүүрэн цагаан сахалтай өвгөн хүний нар салхинд гандаж хүүришсэн бараа, бодолд эргэлдэн дурслын сайхан болж хоцорсон байлаа.

Энэ зуны амралтаар нутагтаа харьж Буурал ханы энгэрээр хонь хариулж нэг өдөр явахдаа энэ сайхан дурслын хуудсыг сөхөж билээ.

Өвгөн бид хоёрын үргэлж суудаг тэр дошны ээвэр талд нэг шороон овоо гарсан байлаа. Чингээд энэ шороон овооны тухай хүмүүс надад ийм нэг үлгэр ярьж билээ.

Эрт арван хэдэн жилийн өмнө, нэг их настай болсон өвгөн нэг хүүтэй энүүгээр хонь хариулж явсан байжээ. Тэр хүү, өвгөний сэтгэлд нар болж явсан гэнэ шүү. Чингээд өвгөн энэ хүүд нэг насны санаж сарвайж явсан ажил үйлээ найдаж, амьд дээрээ үзэж дийлэхгүй ч, үхсэн хойноо үзнэ гэж, хүүрээ энд оршуулахыг хүмүүст захисан байжээ.

Хангай ээлүүд нутгийн энгийн нэг өвгөн, мөн ч хүн төрөлхтний амьдарч тогтнох дархан голомтод хүний нэг хүй залгаж мөчилж явсан тийм нэг сайхан өвгөн, хүн байгалийн аж амьдралд насаа элээхдээ юу санаж эрмэлзэж явлаа гэдгийг та бодож олсон уу? Найз минь.

Нарны мөнхийн юмыг тэр өвгөн авчирсан эсэхийг мэдэхгүй. Гэвч хүний хойчис нарны мөнхийн гэрлийг хормойлж, Буурал ханы энгэр хормойд гялбуулж, өвгөн хоньчин ч нарны мөнх шаргал гэрэлтэй өнөдийн зоогоо дэлгэж, хүн байгалийн өөд эсрэгт Буурал ханаа дэрлэнхэн хийморь сэргэн хэвтжээ (Мөнхийн зоог, 1984: 19-20).

«Мөнхийн зоог (ярилцаа)» найруулалд дотоод логик холбоотой, адил төстэй хоёр эхийг оруулсан. 1. Нартай яриа дэлгэж, нар шиг залуу болох “мөнхийн юм”-ыг нарнаас гуйж явсан өндөр сүүдэртэй өвгөний үлгэр, эртний домог байж болно. 2. “Надтай зоогдож” явсан энгэр дүүрэн цагаан сахалтай өвгөний үлгэр. Сүүлчийн өвгөний үлгэрийг зохиогч дундуур нь таслан, “Надтай” зоогдож, “надад” үлгэр ярьж явсан амьд сэрүүн үеийн үйл хэрэг болон нас барсны дараах үлгэр гэж хоёр хэсэг болгожээ. Ингэж бичсэн гол зорилго нь “тэр хүү, өвгөний сэтгэлд нар болж явсан гэнэ шүү” гэж зохиолын далд санаагаа дэлгэж бусад хүний амаар “тэр хүү, өвгөний сэтгэлийн нар байсан юм” гэж хэлэх нь нэгдүгээр биеийн бичлэгээр “тэр өвгөн намайг сэтгэлийн нар гэж үзэж байлаа” гэх буюу “би бол тэр өвгөний сэтгэлийн нар байлаа” гэх мэтчилэн бичих нь эвлэг зохимжтой. Ингэж сүүлчийн үлгэрээ тасалж “Шороон овооны үлгэр”-ийг ярьдаг, нартай хуучилж суудаг өндөр сүүдэртэй өвгөний үлгэр ба надтай хуучлан суудаг цагаан сахалтай өвгөний үлгэр утгаа нэг.

Өндөр сүүдэртэй өвгөний нартай зоогддог /ярилцдаг/ үлгэр бол цэвэр домог-үлгэр байна. Иймэрхүү домог-үлгэр ардын дунд яригдаж байжээ. “Цагаан сахалтай өвгөн”-ний домог-үлгэрийг хойч үедээ сургамжилж, уламжлан өгч байна. Үүнээс үзэхэд түүх соёлын уламжлагдах хэлбэр мөн бодитойгоор хэлбэл өмнөх хүмүүс амьдралын туршлагаа хожмын бидэнд уламжлан үлдээсэн. Гэвч “Нартай зоогддог өндөр сүүдэртэй өвгөний үлгэр” ер байгаагүй энэ бол “Надтай зоогддог цагаан сахалтай өвгөн”-ий санаагаараа зохиосон зүйл ч байж мэднэ гэж үзвэл “Нартай зоогддог өндөр сүүдэртэй өвгөн” гэдэг нь хэрэг дээрээ “Надтай зоогддог тэр хүү цагаан сахалтай өвгөн” байж, тэр өвгөн “энэхүү хонь сайхан хариулдаг хүү”-г өөрийн амьдралын арга хэлбэр /Үндэстний түүх соёл/-ын хүлээгч тухайлбал монгол соёлын өв хөрөнгийн залгамжлагч гэж үзэхдээ, ирээдүйн соёлын нар гэж бодохдоо “Намайг” нар

гэж далдуур зүйрлэсэн нь үлгэрт тохож үл мэдэгдэм илрүүлсэн байхаа ер нь аль ч талаас нь бодоход ч зохиолын сүүлийн хэсэг, тухайлбал *“Энэ зуны амралтаар нутагтаа харьж Буурал ханы энгэрээр хонь хариулан нэг өдөр явахад...”* гэх шилжилтийн хэсгээс *“өвгөн хоньчин ч нарны мөнх шаргал гэрэлтэй өнөдийн зоогоо дэлгэж хүн байгалийн өөд эсрэгт Буурал ханаа дэрлэнхэн хийморь сэргэн хэвтжээ”* хүртэлх төгсгөл хэсэгт зохиогч “үлгэр”-үүдээ хумихын хамт гол санаагаа дэлгэжээ. Тухайлбал хүн төрөлхтний амьд бодисын амь насан нь эртнээс үеийн үед уламжлан бадрахтай адил тэдний соёлын амь нас нь ч эртнээс уламжлан бадардаг. Хүн төрөлхтөн ийм. Хүн төрөлхтний нэгэн бүрэлдэхүүн болсон үндэстэн мөн л ийм байдаг юм байна. Тус зохиолын энэ үндсэн санаа хэдэн өгүүлбэрт тодорхой илэрсэн юм. Энэхүү гурван өгүүлбэр бол зохиолын адил бус гурван хэсэг — эхлэл, дунд, төгсгөлийн хэсгийн гурван оньс мөн. Жишээ нь: *“Ай хө, хүү минь хонь сайхан хариулдаг юм байна шүү. Сайн малчин болох нь гэгчихсэн бүдүүн гэдэстэй хөгшин цавьдартайгаа шогшуулсаар миний захад ирж, жилийн дөрвөн улиралд хонь яаж яаж хариулахаас эхлээд, Буурал ханы тухай заримдаа бүүр ч “Саях жил аав нь...” гээд л арвин сайхан учиртай юм ярьдаг байлаа”*. Өвгөн яг бяцхан хүүгийн *“Хонь сайхан хариулдаг”*-аас нь түүнийг өөрийнхөө *“Мөнхийн зоог”* соёлын амь насаа гэж бодох болсон ба түүнийг нартай адилтгах болсон юм. Түүнд маш олон зүйлийг учирлан ярьжээ. Ер нь ингэж учирлан ярих хэлбэр бол яг хүн төрөлхтний өмнөх үеэс залгамжлан авсан түршлагаа шинэ амьдралын агуулгаар нөхөж, хойч үедээ уламжлах үндсэн аргын нэг мөн.

“Үнэндээ тийм байна шүү. Залуухан байгалийнхаа элгэнд нартай зоогдож өвгөрнө гэдэг сайхан шүү, хүү минь” гээд өвгөн гуай өтгөн урт хөмсөгөө өргөж намайг харж инээх нь яг л нараа олж үзсэн шиг тийм л хөгжилтэй байлаа” гэж бичсэн энэ хэсэг бол зохиолын бэлгэдэл санаагаа эчнээ далдаас илэрхийлсэн хэлбэр юм. Тухайлбал нар бол хүү мөн, хүү бол нар мөн. Хүн төрөлхтний соёлын амин сүнс, үндэстний соёлын амин сүнс *“мөнхийн зоог”* болж, хэзээд мөхөшгүй, сөнөшгүй байдгийн үндсэн шалтгаан нь яг энэ мэт үе удам залган хөгжиж чаддагт нь байгаа юм. Энэхүү утгаас үзвэл зохиолд *“үлгэр”* ярьж байгаа *өвгөн хоньчин* бол хэрэг дээрээ үндэстний соёлын бэлгэдэлт дүр юм. Харин *“үлгэр”* сонсогч *“би”* бол *өвгөн хоньчны* залгамж хойч болно. Энэхүү санаагаа зохиолд бас *“Ер нь чингээд сайхан нартай хөдөөгийн бэлчээрт тийм нэг өвгөн хүний нам дөлгөөн яриаг сонсож суух нь яг л хүн байгалийн эртний их урсгалын чимээг чагнаж байх шиг учиртай гоёхон санагдаж байж л дээ”* гэж давтан өгүүлжээ. Ингэхлээр тус зохиолд зөвхөн *“өвгөн”* ба *“миний”* үлгэрийг биш харин хүн төрөлхтний агуу их туршлага хэрхэн уламжлагдан дамжиж байдаг тухай том санааг өгүүлсэн зохиол юм. Нөгөөтэйгүүр, өвгөн үлгэрийг дуртайяа уламжлан хүүрнэхэд хүү ч түүнийг баяртай сонсож суудгийг *“Эртний их урсгалын чимээг чагнаж байх”* шиг гэсэн нь тэдний залгамж харилцаа тун эвлэг зохицлоо олсны илэрхийлэл болно.

“Эрт арван хэдэн жилийн өмнө, өндөр сүүдэртэй болсон өвгөн нэг хүүтэй энүүгээр хонь хариулан явсан байжээ. Тэр хүү өвгөний сэтгэлд нар болж явсан гэнэ шүү. Тэгээд өвгөн энэ хүүд нэг насны санаж сарвайж явсан ажил үйлсээ найдаж амьд дээрээ үзэж дийлэхгүй ч, үхсэн хойноо үзнэ гэж хүүрээ энд оршуулахыг хүмүүст захисан байжээ” гэх хэсгийг зохиолын тайламж гэж үзэж болно.

Хураангуйлбал байгаль орчлонд хүн төрөлхтөн амжилттай оршин тогтнож чадсаны чухал нэгэн шалтгаан гэвэл өмнөх үе нь хойчистоо амьдралын туршлагаа амжилттай уламжлан өгч, хойч үе нь шинэ агуулгаар нөхөж чадсанд буй.

Энэхүү логигоор үзвэл ямар нэгэн үндэстний соёлын амжилттай хөгжин бадарч чадах эсэх нь уламжлуулан өгөх ба цаашид төгөлдөржүүлэн залгамжлуулахад буй. Зохиолын гол санаа нь яг үүнд байна. Тухайлбал өвгөн нь хүүхдэдээ үлгэр ярьсан явдлаар дамжуулан хүн төрөлхтний соёлын уламжлал, ялангуяа монгол үндэстний соёлын уламжлал бол бидний “Мөнхийн зоог” мөн гэсэн санааг илтгэжээ.

Тус зохиолд бэлгэдлийн аргыг тун чадмаг ашигласан. Зохиолч дүрийг сонгосон нь бэлгэдлийг агуулдаг юм. Мөн ёгтлолыг ашиглан санаагаа нууж чаджээ. Жишээлбэл, “өвгөн хоньчин”, “нартай ярилцсан өвгөн”-ний үлгэрийг хүүхдэд ярьж байсныг уншигчид, энэ бол нэг өвгөний хоёр үлгэр мөн гэж ойлголгүй төөрөлдөж мэднэ. Хэрэг дээрээ “хоньчин өвгөн”, өөрийн үлгэрээ “надад” ярьж байсан юм. Энэхүү зохиол богинохон хэдий ч сэдэв, агуулга том, сургамж санаатай болжээ. Зохиолоор “Нар мандах, шингэх, дахин мандах...” нь байгалийн зүй тогтол бөгөөд “хүн төрөх, өтлөх, үхэх, шинэ амь мэндлэх...” нь хүн төрөлхтний жам ёс гэдгийг ойлгуулахаар зорьсон юм.

“Нүүдэлчний намар” найруулал

Нүүдэлчний намар

“Салхи сэвээд л

Өрх дэрвээд л

Өлөн тоос дэгдээд л

Айлууд нүүгээд л

Амрагууд холдоод л

Ай хөөрхий

Нүүдэлчний намар аа”

Яруу найрагчийнхаа энэ шүлгийг уншиж, нүүж явсан газраа санахад, тэнгэр нь тоосрон, үүл нь уруугаа бөмбөлзөн, айлуудынхаа нүүдэл тосч хол газар дэрвэсэн хөтөл шилийн шар зөрөг нэг л гүн эзэнээ, уйтгарлангуй гэнэн аясаараа сэтгэл эзэмдэж буудаг юмаа. Нүүнэ гэж ийм байдаг сан.

Нүүхийг нь мэдсэн юм шиг тэр өдрийн өнгө ч үнэхээр ондоо юм даа. Уулсынхаа оройг зөөлөн таалж, нар нь газраасаа хөөрөх тэр хоромд, нүүх үү байх үү гэсэн сэтгэлийн зай дундуур юу бүхэн нь тээж үүрд мартагдашгүй амьсгасан өдрүүдийн нэг шогшиж ирдэг ээ!

Уул хадаа эзэгнэн, чулуудынх нь тоолонгоор жигүүр сөдөө идэршүүлж, элээж явсан орог буурал тас, урдхан янцагааж, униар татсан газартаа хоргодон дүүлсээр хоцордог өдрүүдийг би нүүдэл дундаа ингэж харж ухаарлаа.

Манайх нүүлээ.

Шараа хүлэх гэснээ байж, хүлгэлзэн зогссон аавын царай өнгөө алтан, амьсгаа нь хүртэл эвгүйрэн, барьсан эвэгчээ алдан завдаж, хонин бор толгодынхоо чулууг тоолж байна хэмээрхэн холыг харна.

Ээж минь тэр гэрийнхээ бууцан дээр байн байн дахин очиж, манасан галаа хоёр алгаараа санан санан хөнгөхөн давтана...

“Болжээ ээ, хөө! Яах гээд л. Мөд...” гэж аав санаа алгасан байгаагаа буруулах гэж, бүр л ээжийн буруу юм шиг ээж уруу хандан ширүүн ширүүн дугарсан ч хоолой нь эрхгүй зангиран байхаар нь үзхэд сэтгэл хүнд байгаа нь илхэн.

“Хөөрхий, утаа гарч байх шиг юм, одоо нэг жаахан тос өргөсөн бол...” гэж, ээж аав зүг алхаснаа шинэхэн шороогоор дарж манасан галруугаа эргэн харахад нүдэнд нь нулимс галбаганаж байлаа.

Энэ газар усан дээр насаа элээж явахдаа юу эс үзэн, юу эс ярьж хийж явсангүй бий да гэхээс юундаа цоо хоргодож татагдаж болох хоёр сайхан сэтгэлтэн, ангирын зулзага шиг ганганалдан Хоцронгуй хүүхдээ эргэн эргэн харагшана аав ээж хоёр минь хөөрхий яа! Элж яваа насныхаа эрхээр хиа гэж бодоод хийж чадахгүйгээ, гөрье гэж зүтгээд хүрч чадахгүйгээ мэдсэн хүмүүний санаа сэтгэлийг хүндлэн өргөх хайр, тэднийхээ хайрлаж санаагийг нь хайрлаж санаж явах сэтгэл манд эрхгүй дүрнэ. Энэ их аз жаргал, сэтгэлийн хүнд зовлонь би ийм хоёр сайхан нүүдэлчин дагаж байж тусж авсан хүмүүн да. Дар нэг намар, манайх бас л нүүх боллоо.

Миний хувьд, сэтгэлд эзгүйрэн хоцрохоос гэрийн баруун хойно байдаг дар жаахан доош л байлаа.

Өчигдөрхөн хүртэл баруун духан дээр нь гураван дүүтэйгээ наадаж, чулууг нь хүртэл эвгүй гишгичихээсээ хичээж,

“Энд нэг бух байна өө”

“Энд нэг доголлон ишиг байна”

“Энд нэг айл байна гэнэ дээ”

“Энд нэг аав ээж хоёр байна гэнэ дээ” гэж үзсэн тааралдсан чулуугаа тойрон дөрвүүл тоглож байсан минь эрхгүй санагдана.

Тэгэхэд, өчигдөр би нэг чулууг уг оронд нь тавилгүй хаяснаа гэнэт санаж, ингээд нүүгээд явчихвал тэр чулуунд хэмжээгүй их осол буруу явах шиг дотроо элдвийг бодно. Хамгийн бага дүүгээ дуудаж “ямар ямар чулууг хаа хаа нь тавьчаад ир, мэдэв үү? Аавд бүү үзэгд, би харж байя” гэв.

Дүү минь гүйлээ.

Аав бүү л үзээсэй гэж би их айж, дүү хэнисэн болж зогслоо.

“Хөөе! Ловшийн зулзага чи хаа явна гэж?” гэж аав гэнэт бархирав.

Дүү дандаа зогсож, толгойгоо маажих цүү биш, өмдөө татах цүү биш юм болж: “Цэрэн ах нэг чулууг оронд нь тавьчаад ир гэсэн” гэв.

“Юу? Юунд эртхэн явдаггүй юм? Нүүлээ гээд байхад. Хэдүүлээ явъя” гэж аав санаанаас гадуур зөөлөн дугарав.

Бид хэдүүл баярлаж, тавхай гялалзуулан гүйлцэв ...

Ийм л сэтгэл эмзэгхэн газар ус, хүмүүн ард даа.

Ийм газар ус хүмүүн ардаа харж дүүрэхэд юу бүхэн нь ухаан сэтгэлд уг ивж хайр өгнө. Энэ сэтгэлийнхээ тэнхээгээр намаржин, жилжин, насаараа энэ хорвоогийн нар салхи, мөндөр гялбаанд цохигдож, дэлсэгдэж шарагдаж, униартай газар харж уяран гэнсэрч, уултай газар түшиж амьсгаа авч, тал таарахаар нь дуулж, далд орохоороо уйлж, бид нүүж явсан улс, нүүж ирсэн улс даа.

Нүүдэлчин хүмүүний тэрхүү гандан бууриггүй зүс царай, хайр сэтгэл, өнө холын тэсвэр тэвчээр, үүрдийн дөлгөн ааль ... Нүүдлийн тэр их харгуйгаар их олон юм шуугьж хүрчигнэж нүрэлхийлж исгэрч өнгөрнө. Нүүж буугаад эргэж харахад сэтгэлд их олон юм гүйж ирэх шиг санагдана. Дугуйран цэнхэрлэж дуниартсан уулсын орой нараа тосож гүйлцэн, ухаарч томоожихын их халыг амсуулсан ертөнцийн тэр нэгэн үдшийг сэтгэлдээ харж зогсоход, дурлаж хайрлахын өндөр, дурсаж мөрөөдөхийн жигүүр, итгээж тэмцэхийн идэр хүрэн дэлхийгээ амьсгаж ханашгүй өө... 1988, 4, 18 Шилийн хотод (Нүүдэлчний намар, 1988: 9).

Саахалтын нүүдэл тосч хол газар дэрвэсэн нэг модон тэргэний мөөр хийгээд унаа малын хөлд элэгдэж гарсан хөдөөгийн зам болох “Хөтөл шилийн шар зөрөг”-ийг

тодотгосон нь байгалийг хүнчлэн амилуулсан дүрслэл юм. Үүнээс бид хүүхдийн сэтгэлд байгаль хүртэл хүүхдийн зантай аальтай байгааг мэдэж болно.

“Юу бүхэн нь тэгж үүрд мартагдашгүй амьсгасан өдрүүд” гэж байна. Үүнд “амьсгасан” гэдэг үгийг зөв ойлгох хэрэгтэй. Ерийн үгэнд “дээгүүр амьсгах” гэвэл өвөр монголчуудын ойлголтоор дээрэнгүй царай гаргах буюу дээрэнгүй авир зан гаргахыг заадаг, “... мартагдашгүй амьсгасан өдрүүд” гэдэг нь мартагдашгүй дүр төрх “уур амьсгал” буюу хөг аястай өдрүүд болно.

Энэ найрууллын гол утга санааг илэрхийлсэн “манасан гал”, “дош”, “үг ивэх”, “дуниартсан” гэх үгс байна. “Манасан гал монгол гэрийн буурин дээр унтраахаар дарж тавьсан галыг зааж байна. Монголчууд гал голомтоо халдаж болошгүй ариун дагшнаар үзэж дээдлэн шүтдэг тул “унтраах”-ыг шууд хэлэлгүй цээрлэн хэлэх тохиолдол бий. “Дош” — овойж мөстөн хөлдсөн газар, нүхний амсрын овгор газар: тарваганы дош (тарваганы нүх, ичээ хавийн овгор товгор газар)-ийг хэлдэг байна. “Үг ивэх” — дотно яриа өрнүүлэх гэх утгаар хэрэглэсэн. “Дуниартсан” гэдгийн шилжсэн утга нь *нозоорох, талимаарах* гэсэн үг. Тус найрууллын гол санаа нь намар цагийн нүүдэлчний амьдралын нэгэн хэсгийг хүүхдийн сэтгэлээр дүрслэн харуулахаар дамжуулан монгол нутаг, монгол амьдралаа хайрлах гүн сэтгэлгээг сургамжилжээ.

Энэхүү бүтээл нь бичлэгийн хувьд уянга, хүүрнэл хосолсон харилцан ярианаас бүрджээ. Хамаг дүрслэл нь харилцан ярианаас илэрнэ. Мөн учирлал, шүүмжлэлийг уялдуулан хэрэглэсэн нь тохиолдох боловч уянгын аяс нь давамгайлах тул уянгын найраглалд багтаан задлавал зохимжтой.

Тухайн бүтээлийг үндсэн гурван хэсэгт хувааж болно.

1. Эхлэлээс аваад “... *би нүүдэл дундаа ингэж харж ухаарлаа*” хүртэл бол зохиолын эхний хэсэг болно. Зохиогчоос Б.Явуухулан найрагчийн “Нүүдэлчний намар” шүлгээс иш татан түүнээс сэдэв авч өөрийнхөө “Нүүдэлчний намар”-ын удиртгал аясыг чавхдаж зохиолынхоо үндсэн хөгийг тогтоосон байна. Үүний дараа зохиогчийн уянга хүүрнэл нь их шүлэгчийнхээ сонгодог бадгаас шууд мэдэрсэн “*нэг л уйтгарлангүй гэнэн аяс*”-аас аяндаа өөрийн сэтгэл уруугаа шилжиж “*нүүх үү, эс нүүх үү*” гэсэн бодрол дундуур хөтөлдөг. “*Уул хадаа эзэгнэн чулуудынхан тоолонгоор жигүүр сөдөө идэршүүлж, элээж явсан орог буурал тас, уртхан янцагааж униар татсан газартаа хорогдон дүүлсээр хоцордог өдрүүдийг би нүүдэл дундаа ингэж харж ухаарлаа*” хэмээн нүүх тэр өдрийн гунигт байдлыг ийнхүү дүрслэн бичсэн байна.

2. “*Манайх нүүлээ*” гэж эхлээд “... *ухаан сэтгэлд үг эвж хайр өгнө*” гэдгээр төгсөж байгаа хэсэг бол гол хэсэг болно. Зохиогчоос “манайх гэдэг айлын” хэмээн хоёр удаагийн нүүдлийг эргэцүүлэн бичиж өөрийн хүүхэд ахуй насны дүр зургийг тодруулан, “*манайх нүүлээ*” гэдгээс “*ийм хоёр сайхан нүүдэлчин дагаж байж тосч авлаа*” хүртэл нэг удаагийн нүүдлийн тухай эргэцүүлэмж гарна. Энд голдуу ээж, аав хоёрын харилцан яриа, үйл хөдлөлийг эргэцүүлсэн байна. Энэхүү эргэцүүлэлд харьж яваа насныхаа төгсгөлд хийе гэж бодсон ч хийгээгүй, бүтээе хэмээн бодсон ч бүтээж чадаагүй аав, ээжийнхээ санаа сэтгэлийг хүндлэн өргөх хайр, сэтгэлээр бичсэн. “*Тэр нэг намраас ... юу бүхэн нь ухаан сэтгэлд үг ивж хайр өгнө*” хүртлэх нөгөө нэг нүүдлийг эргэцүүлэн бичжээ. Уг эргэцүүлэмжид “*би*” баатрын үйл хөдлөл, бодол, сэтгэлийг дүрслэв. Мөн энэ хэсэгт ахынхаа үгээр “*тоглож байсан*

чулуугаа уг оронд нь тавихаар гүйлдэж” буй дүү нар нь “аавынхаа зөөлөн дуугарахыг сонссон” хэдий ч “тавхай гялалзуулан гүйлдэв” гэж гарч байгаа нь Монгол нутагт төрсөн хүүхэд болгонд газар усны чулуу нь хүртэл, тэр газар усанд дээр аж төрөх хүн ард нь хүртэл ухаан зааж хайр өгдөг гэсэн санааг ухааруулжээ.

3. “Энэ сэтгэлийнхээ тэнхээгээр...” гэж эхлэн уг зохиолын төгсгөл хүртэл гэх хэсэгт зохиогчоос уянгын тайлал хийжээ. Зохиогчийнхоор бол нүүдэлчин хүн гэдэг сэтгэл эмзэгхэн газар ус, хүн ардаасаа олсон сэтгэлийн тэнхээгээрээ энэ хорвоогийн нар салхи, хатуу ширүүнийг туулж амьдардаг гэсэн бол газар ус нь мөн л “хүн ардтайгаа адил үүрд сэтгэл эмзэгхэн уйлж дуулж насыг бардаг” хэмээн дуусгажээ.

ДҮГНЭЛТ

Ерөнхийдөө их зохиолч Б. Явуухулангийн “Нүүдэлчний намар” шүлгийн мөр бадгаас шууд сэдэвлэсэн тайлал нь хэмээн дүгнэж болно. Д.Цэрэнванжил нь Өвөр Монголын одоо үеийн утга зохиолын найрууллын төрөлд хувь нэмрээ оруулсаар буй юм.

XX дугаар зууны далаад оны дунд, “Соёлын хувьсгал”-ын сүүлчээр Мао Зэдүн “Нам төрийн бодлогын алдааг залруулах хэрэгтэй, ойрын жилүүдэд уран сайхны тоглолтыг бага багаар өргөтгөх хэрэгтэй, үлгэрийн зохиол, найруулал, уран бүтээлийн шүүмж дутаж байна” гэж зааварласан үеэс Хятад орон даяар утга зохиол урлагийн ажил сэргэсэнд түүний дотор Өвөр Монголын утга зохиол сэргэж, уран зохиолын шинэ үе эхэлсэн. Энэ үеийн онцлох уран бүтээлчид болох Энхтөвшин, Лигдэн, Артай, Д.Цагаан, Н.Бөххад, Т.Цэцэн, Л.Одсэр, Н.Шил, П.Цогтнаран, Ё.Эрдэнэтогтох, Д.Цэрэнванжил зэрэг уран бүтээлчид өөр өөрийн арга хэлбэрээр уламжлал шинэчлэлийг хослуулан зохиол бүтэлээ туурвиж эхэлсэн юм. Тэд монгол яруу найргийн хэлний гайхамшиг, соёлын өгүүлэмжүүдээрээ Өвөр Монголын одоо үеийн нүүдэлчний яруу найргийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар явна.

Ном зүй

- Байгалсайхан, С. (1995). *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.
 Гаадамба, Ш. (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар.
 Мөнхийн зоог (1984). «Шилийн гол» сэтгүүл. 6. 19-20 тал.
 Нүүдэлчний намар (1988). «Залуучууд» сэтгүүл. 9.
 Урсгал, С. (2010). *Монгол шүлэг зүй ба утга зохиолын түүх зүй судлал*. Хөх хот.

References

- Baigalsaikhan, S (1995). *Introduction to literature*. Ulaanbaatar (in Mong.).
 Gadamba, Sh. (1989). *Theoretical foundations of literature*. Ulaanbaatar (in Mong.).
 Mönhijn zoog (1984). «*Shilijn gol*» setgyyl. 6. 19-20 (in Mong.).
 Nүүdelchnij namar (1988). «*Zaluuchuid*» setgyyl. 9 (in Mong.).
 Ursgal, S (2010). *Mongolian poetry and literary historiography*. Hoh hot (in Mong.).